



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2013 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 01

Арвайхээр

Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг зогсоох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний гаралт, тархалтыг бүрэн хяналтанд авах, голомтыг устгах, эрүүл болон хамгаалалтын бүс үүсгэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын А/93 дугаар тушаалыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газарт:

1.1. Малын гоц халдварт шүлхий өвчний тандалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, сэжиг илэрсэн тохиолдолд нөхцөл байдлыг цаг алдалгүй шуурхай мэдээлж лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах

1.2. Аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчин гарах эрсдэлтэй газар, бүс нутгийн зураглал гарган мэдээлэх ажлыг тогтмол зохион байгуулах

1.3. Мал, амьтны гоц халдварт өвчний дэгдэлт нэмэгдэж байгаа нөхцөл байдлыг харгалзан бүх түвшинд албаны бэлэн байдлыг хангах, шаардлагатай вакцин, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, бусад багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх

1.4. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

1.5. Сумдын мал эмнэлэг, үржлийн тасаг, нэгжийн малын эмч нарт шүлхий өвчний сүүлийн үеийн мэдээллээр мэдлэг олгох, зөвлөмж хүргэх

1.6. Мал, амьтанд дархлаажуулалт тогтоох зорилгоор таригдаж байгаа вакцины тархлаа тогтоох хугацаа, тарьснаас хэд хоногийн дараа мах, сүүг хүнсэнд хэрэглэж болох талаар дэлгэрэнгүй мэдээллийг орон нутгийн мэдээллийн хэрэгслүүд болон тараах материалаар иргэдэд хүргэх

1.7. Мал сүрэгт намрын ангилалт, заазлалт, хээлтүүлэгч шинээр нөхөн тавих, угаалга, туулгалт, вакцинжуулалтын ажлыг технологийн дагуу хугацаанд нь чанартай хийх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, сайтар зохион байгуулах

1.8. Аймгийн хэмжээнд Хорхорин, Хужирт, Зүүнбаян-Улаан, Тарагт, Өлзийт, Хайрхандулаан сумдад гоц халдварт шүлхий өвчин гарч зарим сумдад дэгдэлт

123000001



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР**

2013 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 01

Арвайхээр

Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг зогсоох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний гаралт, тархалтыг бүрэн хяналтанд авах, голомтыг устгах, эрүүл болон хамгаалалтын бүс үүсгэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын А/93 дугаар тушаалыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газарт:

1.1. Малын гоц халдварт шүлхий өвчний тандалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, сэжиг илэрсэн тохиолдолд нөхцөл байдлыг цаг алдалгүй шуурхай мэдээлж лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах

1.2. Аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчин гарах эрсдэлтэй газар, бүс нутгийн зураглал гарган мэдээлэх ажлыг тогтмол зохион байгуулах

1.3. Мал, амьтны гоц халдварт өвчний дэгдэлт нэмэгдэж байгаа нөхцөл байдлыг харгалзан бүх түвшинд албаны бэлэн байдлыг хангах, шаардлагатай вакцин, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, бусад багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх

1.4. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

1.5. Сумдын мал эмнэлэг, үржлийн тасаг, нэгжийн малын эмч нарт шүлхий өвчний сүүлийн үеийн мэдээллээр мэдлэг олгох, зөвлөмж хүргэх

1.6. Мал, амьтанд дархлаажуулалт тогтоох зорилгоор таригдаж байгаа вакцины тархлаа тогтоох хугацаа, тарьснаас хэд хоногийн дараа мах, сүүг хүнсэнд хэрэглэж болох талаар дэлгэрэнгүй мэдээллийг орон нутгийн мэдээллийн хэрэгслүүд болон тараах материалаар иргэдэд хүргэх

1.7. Мал сүрэгт намрын ангилалт, заазлалт, хээлтүүлэгч шинээр нөхөн тавих, угаалга, туулгалт, вакцинжуулалтын ажлыг технологийн дагуу хугацаанд нь чанартай хийх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, сайтар зохион байгуулах

1.8. Аймгийн хэмжээнд Хорхорин, Хужирт, Зүүнбаян-Улаан, Тарагт, Өлзийт, Хайрхандулаан сумдад гоц халдварт шүлхий өвчин гарч зарим сумдад дэгдэлт

123000001

буурахгүй байгаатай холбогдуулан цаашид үүсч болзошгүй эрсдэлийг тооцон вакцины нөөц бүрдүүлэх

1.9. Улсын мал эмнэлгийн газарт гоц халдварт өвчний үүсгэгчийг мөрдөн тандах судалгаа хийлгэх саналыг тавих

1.10. Аймгийн Засаг даргын 2017 оны А/453 дугаар захирамжаар малын гоц халварт өвчин гарсан Архангай, Булган, Төв, Сэлэнгэ, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудаас мал, амьтан худалдан авах, тууварлах, тээвэрлэх шилжилт хөдөлгөөнийг 2018 оны 12 дугаар сарын 1 хүртэл бүрэн хязгаарласан тухай олон нийтэд мэдээлэл хүргэж урьдчилан сэргийлэх

1.11. Мал сүргийг гадна, дотно шимэгчээс хамгаалах арга хэмжээг 10 дугаар сарын 20-ны дотор бүрэн хэрэгжүүлж, өвөлжөө хаваржаанд ариутгал хийх арга хэмжээг авах

2. Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газарт:

2.1. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хичнээн толгой мал хамрагдсан, вакцины чанар, үр дүн, өвчний голомтын болон сэжигтэй, хамгаалалтын бүс үүсгэх газар нутгийг хамруулсан эсэх, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт шалгалт, хүлээх хариуцлагын талаар соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах, зөвлөмж, сэрэмжлүүлэг гаргаж малчин өрх, мал бүхий иргэдэд хүргүүлж үр дүнгийн талаар мэдээлэл ирүүлэх

2.2. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх, хамгаалах ажлын хүрээнд халдварт өвчний эм, био бэлдмэлийн хангалт, вакцинжуулалт, өвчлөл бий болсон тохиолдолд хорио цээрийн дэглэм, хязгаарлалтын арга хэмжээг сахиулах үйл ажиллагааг хянаж цаг тухайд нь дүгнэлт, зөвлөмжийг өгч ажиллах

2.3. Гоц халдварт өвчнөөр өвчилсөн мал, амьтныг устгах, халдваргүйжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих

2.4. Мал, амьтны гоц халдварт өвчний голомт үүсгэсэн иргэн хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах

2.5. Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд ажиллаж байгаа мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар голомтын бүсээс мал амьтны гаралтай бүтээгдэхүүн нэвтрүүлэхгүй байх, амьд мал тээвэрлэсэн тохиолдолд эмнэл зүйн үзлэг хийж баталгаажуулах, гарал үүслийн гэрчилгээ нэг бүрт хяналт тавих

2.6. Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, чанар, стандартын шаардлагад нийцээгүй, хаана үйлдвэрлэсэн нь тодорхой бус малын эмийн худалдаанд хяналт тавьж зөрчлийг таслан зогсоох

3. Аймгийн Онцгой байдлын газарт:

3.1. Гоц халдварт өвчний голомтыг устгах, эрсдэлийг бууруулж, халдварын тархалтыг хязгаарлах, бүрэн хяналтанд авахад чиглэсэн арга хэмжээг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, заавар, журмын хүрээнд орон нутгийн мэргэжлийн байгууллагуудад бүх талын дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах

3.2. Шүлхий өвчинтэй тэмцэх зааврын дагуу устгалд хамрагдсан малын нөхөн олговор, өвчнийг устгах үйл ажиллагаа, хяналтын цэгүүдэд ажилласан төрийн албан хаагчид, дайчилгаагаар ажилласан иргэдийн албан томилолт, цалин, бусад холбогдон

гарсан зардлын тооцоог хийж, баримтыг бүрдүүлэн Улсын онцгой комисст хүргүүлж шийдвэрлүүлэх

3.3. Хорио цээрийн дэглэм сахиулах хугацаанд Гамшгаас хамгаалах тухай болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээд, аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох

4. Аймгийн Цагдаагийн газарт:

4.1. Хяналтын эргүүлээр ажиллах хүч хэрэгслийг нэмэгдүүлэх, авто тээврийн шалган бүртгэх товчоогоор нэвтрэх тээврийн хэрэгслийг нэг бүрчлэн шалгаж аймгийн Засаг даргын А/453 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

4.2. Сумдад гарсан гоц халдварт шүлхий өвчний үүсгэгч вирусын эх үүсвэрийг олж тогтоох тал дээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

5. Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газарт:

5.1. Гоц халдварт өвчний голомтын болон хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид, иргэдийг өдөр бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах

5.2. Гоц халдварт өвчний голомтын бүсэд байгаа малчин, мал бүхий иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг болон сэтгэл заслын эмчилгээ хийх

6. Сумдын Засаг дарга нарт:

6.1. Бэлчээр, хөрс, хашаа хороо, өтөг, бууцыг ариутган халдваргүйжүүлэх аяныг сум орон нутгийнхаа хэмжээнд сайтар зохион байгуулах

6.2. Малын гоц халдварт шүлхий өвчин гарсан аймгууд болон Хархорин, Бүрд, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Хужирт, Тарагт, Хайрхандулаан сумдаас хурдан морь тээвэрлэх, тууварлах, шилмэл хээлтүүлэгч худалдан авах, тухайн аймаг сумдад худалдан борлуулахыг 2018 оны 12 дугаар сарын 1 хүртэл хориглох

6.3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлж буй Мал эмнэлэг үржлийн нэгжийн үйл ажиллагааг бүхий л талаар дэмжих

6.4. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь (Аймаг, нийслэл, сум дүүрэг нь тухайн жилийн төсвийн 1.0 хувийг орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулна) заалтыг мөрдөж орон нутгийн бэлэн байдлыг хангаж ажиллах

6.5. Малчин болон мал бүхий өрхөд малын халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, мөн хүлээх хариуцлагын талаар сургалт, мэдээллийг өргөн цар хүрээтэйгээр тогтмол зохион байгуулж хэвших

6.6. Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд буй өрх, малчдыг засаг захиргааны нэгжийн харъяалал харгалзахгүйгээр төрийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлж ажиллах

7. Сумдын Мал эмнэлэг үржлийн тасаг, Мал эмнэлэг үржлийн нэгжүүдэд:

7.1. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг тухайн орон нутгийн онцлогт тохируулан (байгалийн тогтоц, цаг уур, зонхилох салхины чиг, ундны ус, хөрс, зам даваа гм) бэлэн байдлыг хангаж зохион байгуулах, хэрэгжүүлэх

7.2. Халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахдаа эрүүл бүсээс голомтруу чиглэлээр ажиллах, тарилгын технологийн алдаа гаргахгүй, мал, амьтан үлдээхгүй нэг бүрчлэн хамруулж тариурын найдвартай байдлыг сайтар шалган вакциныг технологийн дагуу

хадгалж тээвэрлэн, хэрэглээний зааврыг чанд баримтлан хийх, тогтоосон бүсийн дотор мэдэрэмтгий малыг бүрэн хамруулах талаар онцгой анхаарах

7.3. Вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахдаа ямар өвчний дархлааг хэдэн сар, жилийн хугацаатай тогтоосон, хэд хоногийн дараагаас хүнсэнд хэрэглэж болох талаар малчид, мал бүхий иргэдийг үнэн бодит мэдээллээр хангах

7.4. Голомтын болон сэжигтэй бүсийн өвөлжөө бууцанд жилд 2 удаа ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх

7.5. Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 2018 оны төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах

7.6. Сум багийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчин гарах эрсдэлтэй газар бүс нутгийн зураглал гарган орон нутгийн хэмжээнд мэдээлэх ажлыг тогтмол зохион байгуулах

7.7. Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг олгох журмыг чанд баримтлах

7.8. Малын гоц халдварт, халдварт, паразит өвчний мэдээ, мэдээллийн үнэн бодит, шуурхай байдлыг хангах, малчид, иргэдтэй нягт хамтран ажиллаж мэдээ, мэдээллийн хяналт, мониторинг тогтмол хийж ажиллах

7.9. Мал амьтны халдварт, гоц халдварт өвчний хор уршиг, нийгэмд учруулах хохирол, мал эмнэлгийн ач холбогдол, малчид, хувь хүний хариуцлагын талаарх сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж хэвших


7.10. Мал амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах

8. Мэргэжлийн ангиуд болон сумдын Засаг дарга нарт

8.1. Гоц халдварт шүлхий өвчний дэгдэлт буурахгүй байгаа бөгөөд хүйтний улиралд өвчний дэгдэлт ихсэх магадлалтай тул байгууллага бүр өөрийн чиг үүргийн хүрээнд, сумд орон нутгийнхаа болон малчид, мал бүхий иргэдийг өвлийн хүйтэн цагт хохирол багатай даван туулах бэлэн байдлыг сайтар хангуулах талаар арга хэмжээ авч ажиллах

8.2. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг хангаж биелэлтийг тооцон улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлж байхыг сумдын Засаг дарга нар болон холбогдох байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН